



**Ерөнхийлөгч
Даллин Х.Өүкс**
Тэргүүн зөвлөлийн
нэгдүгээр зөвлөх

Наманчлал нь баяр баясал юм!

Наманчлал бол баяр баясгалан бөгөөд Бурханы төлөвлөгөөний чухал хэсэг юм. Бид бүгд наманчлах шаардлагатай.

Наманчлахын тулд бид Есүс Христэд итгэж эхлэх ёстой. Бид гэм нүглээ хүлээж, орхих ёстой. Энэ нь бид хийсэн буруугаа ойлгож, гомдоосон тэднээс уучлал гуйж, илүү сайн сонголт хийнэ гэсэн үг юм. Мөн бид хүндэтгэлийн өдөр бүр ариун ёслолоос хүртэх ёстой.

Бид наманчлах үедээ цэвэр болох болно. Их Эзэн “[бидний нүглүүдийг] цаашид санахгүй” (Сургаал ба Гэрээ 58:42) хэмээн амласан. Ямар гайхамшигтай амлалт вэ! Ямар гайхалтай гайхамшиг вэ! Ямар гайхалтай адислал вэ!

Бидний хайртай Аврагч наманчилдаг, Өөрийг нь дагадаг бүх хүнийг мутраа дэлгэн хүлээн авдаг. ●

“Наманчлалаар цэвэршүүлэгдсэн нь,” 2019 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 111-114-өөс хэсэгчлэн авав.

Дахиад цэвэрхэн

Наманчлалын тухай суралцахад чинь туслах энэ үйл ажиллагааг хийгээрэй!

Чамд хэрэгтэй зүйлс:



1. Шилэн савыг усаар дүүргэ. Дараа нь усанд хэдэн чулуу, мөн шороо хий. Энэ нь бидний хийдэг буруу сонголтуудыг төлөөлдөг.



2. Дахин цэвэрхэн болохын тулд бид буруу зүйл хийхээ болих ёстой. Энэ нь савнаас чулууг гаргахтай адил. Ус одоо ямар харагдаж байна вэ? Ус бохир хэвээрээ байна уу?



3. Бүрэн наманчлахын тулд бидэнд Есүс Христ хэрэгтэй! Бид Түүнд болон Түүний цагаатгалд итгэх хэрэгтэй. Устай савыг цоргоны доор барь. Бүх бохир ус урсан гартал саванд цэвэр ус гоожуулаарай! Энэ нь бидэнд цэвэр болоход туслах Есүс Христийн хүчийг илэрхийлж байна.

